2015 оны 02 сарын 09 өдөр Дугаар А/10 Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.1.4 дэх заалтууд, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дугаар захирамжийн 2.4.1 дэх заалт, 2015 оны А/49 дугаар захирамж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжих Гэр хорооллын айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах, хүчдлийн уналтыг сайжруулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Б.Энхбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга
Гишүүд:	Б.Алтандуулга	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ний Техникийн бодлого шинэчлэлийн хэлтсийн дарга
	Э.Уянга	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн
	Б.Батсүх	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн
	Н.Батцэнгэл	Нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн
	Т.Мөнхбаяр	Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны иргэн
Нарийн бичгийн дарга	Р.Даваасүрэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн

2. Хөрөнгө оруулалтын ажлыг хууль журамд нийцүүлэн яаралтай зохион байгуулж, зөвлөмжийг Нийслэлийн Хөрөнгө Оруулалтын газар /Л.Нарантуяа/-т хүргүүлэхийг Үнэлгээний хороо /Б.Энхбаяр/-нд үүрэг болгосугай.

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8-р зүйлд заасан мэдэгдэл, Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалаар батлагдсан үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг

зохицуулах журмын 2.4-д заасан мэдүүлгийг гаргуулж ажиллахыг Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргад даалгасугай.

ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД

ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ

ДАРГА Б.БАДРАЛ